

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-27-89, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2017.01.20 № 9/210
танай _____-ны № _____-т

Даалгавар өгөх тухай

Хорооноос 2017 онд үнэт цаасны зах зээлд эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоог бүрдүүлэх, үнэт цаас гаргагч буюу хувьцаат компанийн үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг бууруулах бодлогыг баримталж байна.

Иймээс Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 66.1.1, 66.1.3, 66.1.5 дахь заалтуудад заасан нөхцөл байдал үүсэж болзошгүй гэж Хороо үзэж байгаа тул танай компанид дараах хугацаатай даалгаврыг биелүүлж ажиллах шаардлагатай байна. Үүнд:

1. Улсын Их Хурлаас Аудитын тухай хуулийг 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр шинэчлэн баталсантай холбогдуулан Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйл буюу “Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих аудиторын хяналт”-д дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

1.1 Компанийн тухай хуулийн 94.2-т “Хувьцаат компанийн дүрэмд аудитын байгууллагыг заавал ажиллуулахаар заана” гэж заасантай нийцүүлж 2017 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дүрэмдээ нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж батлах;

1.2 Мөн хуулийн 94.3-т “Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороо /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална”, 94.4-т “Энэ хуулийн 94.3-т заасан гэрээнд компанийн болон аудитын байгууллагын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заана” гэж заасантай нийцүүлэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.6-т заасан Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагыг төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороогоор хэлэлцэж, сонгохыг зөвлөж байна. /Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагын жагсаалттай <http://www.frc.mn/org/index?category=81> холбоосоор орж танилцана уу/

1.3 Хороонд бүртгэлгүй аудитын компаниар компанийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн тохиолдолд Хороо хүлээн зөвшөөрөхгүй, дахин аудит хийлгэх шаардлага тавих болно.

1.4 Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.6-д “хагас жилийн болон Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Хороо болон хөрөнгийн биржид хүргүүлэх” гэсэн заалтыг хангаж ажиллахыг үүрэг болгож байна

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д “Аж ахуйн нэгж байгууллага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг дагаж мөрдөнө”, СТОУС 16-ын 32-т “Зарим хөрөнгийн зүйлийн бодит үнэ цэнд мэдэгдэхүйц, тогтмол өөрчлөлт гардаг бол тэдгээрийг жил бүр дахин үнэлэх шаардлагатай. Үнэ цэнэ нь үл мэдэгдэм өөрчлөлттэй байдаг хөрөнгийн хувьд гурваас таван жил тутам үнэлгээ хийх нь тохиромжтой” гэж заасантай нийцүүлж танай компани нь сүүлийн 3 жилийн хугацаанд хөрөнгийн үнэлгээ хийлгээгүй бол компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөр Хороонд бүртгэлтэй хөрөнгийн үнэлгээний компаниар хөрөнгийн үнэлгээ хийлгэх асуудлыг хэлэлцэн сонгож, 2017 оны хоёрдугаар улиралд багтаан хөрөнгийн үнэлгээ хийлгэж,

холбогдох өөрчлөлтүүдийг санхүүгийн тайландаа тусгаж, дүгнэлтийг Хороонд 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлантай хамт ирүүлэхийг мэдэгдэж байна. /Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагын жагсаалттай <http://frc.mn/org/index?category=82> холбоосоор орж танилцана уу/

Хэрэв сүүлийн гурван жилийн хугацаанд хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн бол холбогдох дүгнэлтийг Хороонд ирүүлнэ үү.

3. Хорооны 2008 оны “Ногдол ашиг тараах, хувьцаа эзэмшигчдэд данс нээх ажлыг зохион байгуулах тухай” 38 дугаар тогтоолоор ногдол ашгийг компани дээрээ олгодог, ногдол ашгийг жил дамнуулан хуваарилдаг байдлыг зогсоож, ногдол ашгийг тухайн жилд багтаан “ҮЦТХТ” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчийн дансанд шууд байршуулж байхыг хувьцаат компаниудын удирдлагад үүрэг болгосон.

Тиймээс өмнөх жилүүдэд ногдол ашгийг компани дээрээ олгодог байсан бол хуваарилсан ногдол ашгийн тооцоог бүрэн гаргаж, олгоогүй ногдол ашгийн үлдэгдлийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах тухай гэрээг “ҮЦТХТ” ХХК-тай байгуулж, холбогдох баримтыг, мөн Компанийн тухай хуулийн 46.5-д заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн эсэх талаарх мэдээлэл, хэрэв шийдвэрлэсэн бол “ҮЦТХТ” ХХК-тай гэрээ байгуулж, холбогдох баримтыг тус тус ирүүлэхийг мэдэгдье.

4. Хувьцаат компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахдаа Компанийн тухай хууль, Хорооны 2016 оны 244 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасан шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017 онд зарлан хуралдуулах ажлыг зохион байгуулахдаа дараах шаардлагыг заавал хангахыг Хорооны зүгээс анхааруулж байна. Үүнд:

4.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гаргаснаас хойш гурав хоногийн дотор Хорооны 2016 оны 244 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хороо, хөрөнгийн биржид хүргүүлэх;

4.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг компанийн ерөнхий захиргаа байрлаж байгаа газраас өөр газарт хуралдуулахаар товлосон бол хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн хамгийн их төвлөрөлтэй, аливаа зардал, чирэгдэлгүйгээр оролцох боломжтой газарт хурлыг хуралдуулах;

4.3 Компанийн тухай хуулийн 59.4 дэх заалттай нийцүүлэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулж, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр холбогдох баримт материалыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.8-д заасан хугацаанд буюу хурал хуралдсанаас хойш ажлын гурван өдрийн дотор Хороонд ирүүлэх;

4.4 Мөн хуулийн 59.11, 96.4 дэх заалтуудтай тус тус нийцүүлэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

4.5 Мөн хуулийн 79.3.3 дахь заалттай нийцүүлэн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, гарсан тогтоол, шийдвэрийн талаар мэдээлэл өгөх, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх үүргээ биелүүлэх;

4.6 Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд нь мөн хуулийн 79.1-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хараат бус гишүүдээр бөглүүлэн ирүүлэх.

5. Хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагааны талаарх болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж,

мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам” шинэчлэн батлагдаж, 2016 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

Компанийн үйл ажиллагааны тайлан болон компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад компанийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, түүний эдийн засгийн үзүүлэлт, өмч хөрөнгийн болон удирдлага зохион байгуулалтын бүтэцтэй холбоотой мэдээллийг тус журамд заасан хугацаанд болон өөрчлөлт орсон тухай бүр журамд заасны дагуу мэдээлэхээр зохицуулагдсан.

Энэхүү журмын хэрэгжилтэд хөрөнгийн бирж хяналт тавьж ажиллахаар зохицуулагдсан тул холбогдох мэдээллийг компанийн цахим хуудас болон хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах үүргийг төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захиралд үүрэг болгож хөрөнгийн биржтэй хамтран ажиллах шаардлагатай байна.

6. Хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн батлагдаж, хөрөнгийн биржийн “А” самбар дээр бүртгэлтэй хувьцаат компаниуд энэхүү кодексийг хэрэгжүүлж ажиллах ба бусад хувьцаат компаниуд хэрэгжүүлж байгаа талаараа тайлбарлаж ажиллахыг үүрэг болгосны дагуу танай компани “Компанийн засаглалын кодекс”-ийг хэрхэн хэрэгжүүлж байгаа тайлбар, холбогдох материалыг ирүүлэхийг мэдэгдье.

Дээр дурдсан хугацаатай даалгавар буюу ирүүлэхийг шаардсан тайлбар, баримт материалыг 2017 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд ирүүлэх, түүнчлэн хувьцаат компани нь заавал өөрийн цахим хуудастай байх, цахим хуудасны үйл ажиллагааг идэвхжүүлэх шаардлагатай байгааг анхааруулж байна.

Хэрэв компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах, хуралдуулах, хурлаар хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрүүд нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооны 2016 оны 244 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам” -д заасан шаардлагыг бүрэн хангаагүй тохиолдолд Хорооноос танай компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөр болсонд тооцох боломжгүй гэх нөхцөл үүсэхийг анхааруулж байна.

Мөн Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-д заасан шаардлагыг хангаж ажиллаагүй, түүнчлэн энэхүү албан бичгээр өгөгдсөн даалгаврыг дурдсан хугацаанд Хороонд ирүүлээгүй тохиолдолд танай компанитай холбоотой аливаа тодорхойлолтыг гаргаж өгөх боломжгүй болохийг үүгээр мэдэгдэж байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлээгүй этгээдийг мөн хуулийн 89.1.6, Компанийн тухай хуульд заасан хувьцаат компани энэ хуульд заасан тайлан тэнцэл, мэдээ, мэдээллийг нь нийтэд болон эрх бүхий байгууллага, хувьцаа эзэмшигчид танилцуулах, мэдээлэх, тайлагнах, мэдэгдэх үүргээ биелүүлээгүй этгээдийг 100.1.1 дэх заалтад тус тус заасан захиргааны шийтгэл ногдуулахыг анхааруулж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.АРИУНАА



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС МЭДЭЭЛЖ БАЙНА НИЙТ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН АНХААРАЛД

Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны зах зээлд эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоог бүрдүүлэх, үнэт цаас гаргагч буюу хувьцаат компанийн үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг бууруулах бодлогыг баримталж байна.

Иймээс Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 66.1.1, 66.1.3, 66.1.5 дахь заалтуудад заасан нөхцөл байдал үүсэж болзошгүй гэж Хороо үзэж байгаа тул нийт хувьцаат компаниудад дараах хугацаатай даалгаврыг 2017 онд биелүүлж ажиллах шаардлагатайг мэдэгдье.

Дараах LINK-ээр орж танилцана уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР